



"УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ" ХХК

Улаанбаатар аудит корпораци нь хараат бус аудит, баталгаажуулалт, татварын болон зөвлөх үйлчилгээний дэлхийд тэргүүлэгч байгууллагуудын нэг Грант Торнтон Интернэйшилийн Монгол улс дахь Корреспондент гишүүн (www.gti.org)

Хараат бус аудиторын дүгнэлт

"Хөгжлийн шийдэл" ТББ-ийн Удирдах зөвлөлд:

Бид "Хөгжлийн шийдэл" ТББ (цаашид "байгууллага" гэх)-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-нээрх баланс, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байdag.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол хийсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэв. Энэхүү стандартараар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гээдг үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горим гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж болох эрсдэлийн үнэлгээг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна.

Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор уг компанийн санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, толилуулахтай холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Энэ нь компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар хараат бус дүгнэлт гаргах бус тухайн нөхциөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлоход чиглэдэг. Мөн аудитын ажилд нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэлтэй байдлыг үнэлэх мөн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлэх ажлууд багтана.



“УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ” ХХК

Улаанбаатар аудит корпораци нь хараат бус аудит, баталгаажуулалт, татварын болон зөвлөх үйлчилгээний дэлхийд тэргүүлэгч байгууллагуудын нэг Грант Торнтон Интернэйшилийн Монгол улс дахь Корреспондент гишүүн (www.gti.org)

Бидний хийж гүйцэтгэсэн аудит нь энэхүү гаргасан дүгнэлтэд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, "Хөгжлийн шийдэл" ТББ-ын 2015 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-д нийцүүлэн Сангийн сайдын 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан 385 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн бус байгууллагын маягт, заавар"-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Хүндэтгэсэн,


Б.ОСОРГАРАВ
Ерөнхий захирал

2016 оны 02 дугаар сарын 15